



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТНОРОВ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар A/10

Дундбүрд

┌ **Өмч хамгаалах байнгын зөвлөл** ┐  
**байгуулах тухай**

Монгол улсын Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын арван нэгдүгээр хуралдааны 2022.05.25-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга (Нийгмийн ажилтан)  
Гишүүдэд: (Байгалийн ухааны заах аргын нэгдлийн ахлагч)  
(Нийгмийн ухааны заах аргын нэгдлийн ахлагч)  
(Багын заах аргын нэгдлийн ахлагч)  
(Номын санч)

2. Байгууллагын үндсэн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон зайлшгүй шаардлагатай эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасугай.

3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллан, үр дүнг танилцуулж байхыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулаад 2016 оны 05 дугаар сарын 17-ны А/12 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

~~ЗАХИРАЛ~~



(Г. ЦЭЦЭГСҮРЭН)